

## СУМ, БАГИЙН ЗОХИОН БАЙНГУУЛАЛТ ДОТОРХИ ӨӨРЧЛӨЛТ

Д.Сүхбаатар  
Б.Ринчинноров

**Өгүүллийн товч утга:** Энэхүү өгүүлэлд БНМАУ-д социализмыг дэлгэрэнгүй байгуулах зорилго тавьсан үе бөгөөд энэ үеийн онцлог нь хөдөө аж ахуйд нэгдэл хэмээх нэгж бий болж сум доторх зохион байгуулалт өөрчлөгдсөнөөр социализмд дэвших орох зорилго хэрхэн биелүүлсэн учрыг тодруулах юм.

**Түлхүүр үг:** Сум, баг, нэгдэл, бригад, суурь, хэсэг, УБХТ, социализм, МАХН, нэгдэлжүүлэх хөдөлгөөн,

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12 сарын 1-ны өдрийн 81-р хурлын тогтоолд “багийн доторх өрхийн тоог 50-80, сумын доторх багийн тоог 4-12 байхаар тогтоосон” үүний үрээр БНМАУ-н АИХТ-ийн 1956 оны 8 сарын 1-ны 104-р зарлигаар “14 аймгийн 39 сум 240 баг, 1 хороо, 6 хоринг татан буулгасан байна”<sup>1</sup>.

1952 онд аймаг, хот, сум, хороо, баг, хорины ХДХ-н сонгуулийн дүрмийг баталжээ. Энэхүү дүрмээр сум, хороодод 3000 хүртэл хүн амтай бол 30 тойрог, 3000-аас дээш хүн амтай бол 100 хүн ам тутмаас 1 депутат сонгогдохоор бодож тойргуудыг<sup>2</sup> байгуулахаар зааж мөн баг хороодод 400 хүртэл хүн амтай бол 7 тойрог, 400-аас дээш хүн амтай бол 50 хүн ам тутмаас 1 депутат сонгогдохоор бодож тойргуудыг<sup>3</sup> байгуулахаар болжээ. 1952 онд анх удаагаа орон нутгийн сонгууль шинэ системээр явуулсан юм. Энэхүү сонгуулиар сум, хороо ба баг, хорьдын хөдөлмөрчин ардын хурлуудын гүйцэтгэн захирах байгууллагуудыг байгуулах мөн хурлуудаар 3-13 хүртэл хүмүүсээр нэг жилийн хугацаагаар сонгогдон орон үүний бүрэлдэхүүн нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, захиргааны гишүүд болон хэмээн сонгуулийн

<sup>1</sup> Сүхбаатар.Д. Хасбаатар.Т Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалтын түүхэн уламжлал УБ., 2011. т.159

<sup>2</sup> Болдбаатар.Ж Лүндээжанцан.Д Монгол улсын төр эрхзүйн түүхэн уламжлал УБ., 1997. т.292

<sup>3</sup> Болдбаатар.Ж Лүндээжанцан.Д Монгол улсын төр эрхзүйн түүхэн уламжлал УБ., 1997. т. 292

дүрмэнд зааж<sup>4</sup> өгчээ. Монголын хөдөө аж ахуйд хоршоолох хөдөлгөөн өрнөсний үр дүнд ардын хувийн аж ахуйтнуудын мал сүргийг нийгэмчлэн, 1959 онд хөдөө аж ахуйн нэгдэл байгуулагдаж, нэг нэгдэлд дунджаар 43000 орчим мал сүрэг, 476 өрх, 1161 гишүүн, түүний дотор хөдөлмөрийн чадвартай 744 хүн тус тус оногдох<sup>5</sup> болжээ. Манай оронд 1959 оны эцсийн байдлаар ардын аж ахуйтны 99,3%, бүх мал сүргийн 73,8% нь нийгэмчлэгдэж нэгдэлжих хөдөлгөөн ялсан билээ. Сум нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хувьд нэг нэгдэл буюу сангийн аж ахуйгаас бүрдэх болсныг харгалзан БНМАУ-н АИХТ-ийн 1959 оны 8 сарын 5-ны өдрийн 129-р зарлигаар “50 орчим сум шинээр байгуулж 1700 орчим багийг хэрэггүй шат дамжлаг хэмээн татан буулгасан”<sup>6</sup>-аар сум хороо нь орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгж болж багуудын оронд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бригадыг шинээр байгуулсан.

Хөдөө аж ахуйд социализм байгуулах зорилгоор хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрмийг 1959 оны 12 сарын 25 ны өдөр хуралдсан БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлийн II их хурлаас дэмжигдэж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1960 оны 1 сарын 8 нд батлагджээ<sup>7</sup>. Энэхүү дүрмээр Хөдөө аж ахуйн нэгдэл өөрийн өмнөө тавьсан тодорхой зорилтоо биелүүлж ажиллахдаа, нэгдэгч олны авьяас чадвар хөдөлмөрийн идэвхжилийг удирдан зохион байгуулах байгууллага болох ерөнхий хороогоор удирдуулан нэгдсэн нэг зохион байгуулалттай ажиллана хэмээжээ. Үүний үрээр Хөдөө аж ахуйн нэгдэл бий болсноор нэг суманд нэг нэгдэл буюу нэг сангийн аж ахуй байсан бөгөөд хэдхэн суманд нэгдэл, сангийн аж ахуй хамт байх тохиолдол бий.

Нэгдэл бол суманд бий болсон бөгөөд эхэн үедээ нэгдэл сумын доторх зохион байгуулалт байсан бол аажимдаа сум нэгдэлийн зохион байгуулалт нэг түвшинд очсон нь 1959 оны 3 дугаар сарын бүгд хурлын илтгэлд “одоо нэгдэл бүрийн дэргэд сумын төв байгуулж түүний удирдлагыг хөдөө аж ахуйн нэгдлийн даргатай нийлүүлэх нь зүйтэйг практик аяндаа харуулав. Ингээд цаашид хөдөө аж ахуйн нэгдэл, сум хоёр нэг удирдлагатай байх болно ...” “одоо манай засаг захиргаа, аж ахуйн анхан шатны нэгж нь сум болох юм”<sup>8</sup> гэж дүгнэн хэлжээ. Мөн нэгдэлжих хөдөлгөөн дууссаныг дүгнэж хэлэлцсэн МАХН-ын төв хорооны 1959 оны 12 сарын IV бүгд хурлын илтгэлд “Сумын захиргаа нэгдлийн удирдлагыг нэгтгэсэн явдал бүрэн зөв болсныг амьдрал

<sup>4</sup> Чимид.Б Үндсэн хуулийн үзэл баримтлал: нутгийн удирдлага. Гуравдугаар дэвтэр УБ., 2004. т. 80

<sup>5</sup> БНМАУ-ын түүх. УБ., 1969. т. 594

<sup>6</sup> Сүхбаатар.Д. Хасбаатар.Т Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалтын түүхэн уламжлал УБ., 2011. т. 160

<sup>7</sup> Дамдиндорж.Г Хөдөө аж ахуйн нэгдэл ба түүний удирдлагын эрх үүрэг. УБ., 1965. т. 15.

<sup>8</sup> Цэдэнбал.Ю Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг II боть УБ., 1967. т. 266-267

нотлов”<sup>9</sup> гэсэн дүгнэлт гаргаснаар сум нь засаг захиргааны нутаг дэвсгэрийн хоёр дахь шатны нэгж байснаа анхан шатны, тэгэхдээ “засаг захиргаа – аж ахуйн нэгж” болжээ.

1963 оны VI сард МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл “Хөдөө аж ахуйн нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт хөлс төлөлтийн системийг сайжруулах тухай” тогтоол гаргаж энэхүү тогтоолоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн нэгжийг бригад, суурь болгон зохион байгуулж, хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөр өдрөөр бодож мөнгөөр төлөх болсон байна. Тус улсын дотор 1800 орчим бригад ажиллаж нэг бригадад дунджаар 132 айл, 12 мянган орчим мал ноогдоно гээд сум доторх багийн зохион байгуулалтын нэрийг өөрчлөөд, мөн засаг захиргааны хэлбэрийг хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлсэн байна.

Багийг татан буулгасны дараахан сумын хурал, захиргаа иргэдтэй шууд холбогдсон засаг захиргааны ажил тасалдаж, иргэд ч чирэгдэж эхэлсэн байна. Иймийн учир Намын Төв Хорооны 1959 оны 12 сарын бүгд хурлын илтгэлд “нэгдлийн бригадын даргад сумын захиргааны төлөөлөгчийг хариуцуулах талаар нэлээд газраас тавьж байгаа саналыг зүйтэй гэж үзнэ”<sup>10</sup> хэмээж энэ нь нэг хэсэгтээ хөдөө аж ахуйн нэгдлийн бригадын дарга нар захиргааны үүрэг хавсран гүйцэтгэх удирдамж болсон байна.

1965 оны Сайд нарын зөвлөлөөс “бригадын хөдөлмөрчдийн дунд зохиогдох засаг захиргааны ажлыг цаашид хөдөө аж ахуйн нэгдлийн бригадын дарга нараар гүйцэтгүүлж байхыг сумдын Ардын Депутатуудын Хурлын (АДХ) гүйцэтгэх захиргаадад зөвшөөрсүгэй”<sup>11</sup> гэсэн 497-р тогтоол гаргажээ. Үүнээс хойш нэг сарын дараа Сайд нарын зөвлөлийн 1966 оны 32-р тогтоолоор дээрх заалтыг сангийн аж ахуйн тасаг, биеэ даасан ферм, бригадын дарга нарт хамааруулснаар<sup>12</sup> хөдөөд уг ажлыг хийх эрх зүйн үндэстэй болсон ажээ.

1992 оны шинэ үндсэн хуулиар “Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдаж байхаар зааснаар баг засаг захиргааны анхан шатны нэгж дахин болсон байна. Дахин байгуулсаныг дурсахдаа Өвөрхангай аймгийн Бүрд сумын засаг дарга Б.Гачмаа:

- Нэгдлийн бригадыг түшиж 5 баг байгуулсан. 1 нь төвд, 4 нь хөдөө хэвээр байгаа гэжээ<sup>13</sup>.

<sup>9</sup> Цэдэнбал.Ю Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг II боть УБ., 1967. т. 365

<sup>10</sup> Цэдэнбал.Ю Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг II боть УБ., 1967. т. 365

<sup>11</sup> БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1965. №6 т. 104

<sup>12</sup> БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1966. №1 т. 60

<sup>13</sup> Чимид.Б Багийн өнгөрсөн одоо ирээдүй УБ., 2002. т. 47

Архангай аймгийн Хашаат сумын засаг даргын газрын дарга  
Х.Лхавгасүрэн:

- 1992 онд хөдөө аж ахуйн нэгдлийн бригадыг өөрчлөлгүй баг болгосон. Одоо ч тэр хэвээрээ 5 багтай. Хөдөөгийн 4 баг, сумын төвийн 1 багтай гэжээ<sup>14</sup>.

	Аймгийн нэр	Сумын тоо	Багийн тоо 2002.5 сарын байдлаар	Төвийн баг			Хөдөөгийн баг
				Төвийн баг бүгд	Аймгийн төвийн баг	Сумын төвийн баг	
	Архангай	19	99	24	6	18	75
	Баян-Өлгий	13	84	24	9	15	60
	Баянхонгор	20	102	25	7	18	77
	Булган	16	73	20	4	16	53
	Говь-Алтай	18	82	10	6	4	72
	Говьсүмбэр	3	9	5	5		4
	Дархан-Уул	4	24	16	16		8
	Дорноговь	14	57	17	5	12	40
	Дорнод	14	65	27	10	14	40
0	Дундговь	15	69	12	9	3	57
1	Завхан	24	113	30	6	24	83
2	Орхон	22	19	17	16	1	20
3	Өвөрхангай	19	108	29	8	21	79
4	Өмнөговь	15	54	11	5	6	43
5	Сүхбаатар	13	67	25	8	17	42
6	Сэлэнгэ	17	49	39	5	34	10
7	Төв	27	102	33	6	27	69
8	Увс	19	89	25	9	19	61
9	Ховд	17	91	28	12	16	63
0	Хөвсгөл	23	120	32	10	22	89
1	Хэнтий	11	83	25	8	17	58
	Бүгд-21	329	1559	474	170	304	1085

<sup>14</sup> Чимид.Б Багийн өнгөрсөн одоо ирээдүй УБ., 2002. т. 47

2008 оны байдлаар Монгол улс засаг захиргааны хуваарьт 21 аймаг 1 нийслэл хот, 329 сум, 9 дүүрэг, 1561 баг 153 хороо байна.

Эцэст нь дүгнэхэд:

Орон нутаг, баг, хороо гэх зэрэг нь юуны өмнө сум, аймаг, нийслэл, улмаар улс гэхчлэн төр улсынхаа байгууламж, улс орны хөгжлийн салаа мөчрүүдтэй амин холбоотой байдаг билээ. БНМАУ-д социализм байгуулах зорилгоор хөдөө аж ахуйгаа социалист аж ахуй болгох хөдөлгөөн өрнөсөн юм. 1959 оны нэгдлийн II их хурал хуралдаж БНМАУ-д нэгдэлжих хөдөлгөөн ялсныг нийтээр зарласан билээ. Нэгдэлжих хөдөлгөөний үр дүнг Ардын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал “Ардын аж ахуйтныг нийгмийн социалист аж ахуйн талд бүрэн оруулсан явдал бол 1921 оны ардын хувьсгалтай эн зэрэгцэх ач холбогдол бүхий түүхэн үйл явдал<sup>15</sup>” хэмээн хэт дөвийлгөн, дэндүү өрөөсгөл дүгнэлт хийсэн юм. Гэхдээ ардын аж ахуйтныг хоршоолсон нь нийгэм эдийн засгийн зохих ач холбогдолтой арга хэмжээ байсныг үгүйсгэх аргагүй. Мөн Ю.Цэдэнбал хэлсэн үгэндээ “манай хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулах явдал бол түүхийн талаар зайлшгүй туйлын чухал зүйл бөгөөд социализмыг байгуулахад заавал гүйцэтгэх нөхцөл мөн<sup>16</sup>” хэмээн дурьджээ.

1950-аад оны нэгдэлжих хөдөлгөөн тус оронд эрчимжиж, олон аймаг сумдад хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй байгуулагдсан билээ. Ингэснээрээ 18 аймаг улаанбаатар хотод нийлээд “улсад 389 нэгдэл байгуулагдаад байна. Дунджаар үзэхэд нэг нэгдэл 475 аж ахуй, 1685 хүн, 59000 мал, түүний дотор 43400 нийгмийн мал оногдож байжээ<sup>17</sup>”.

Тэр бүхэнд оносон нь бий боловч хэрэв жам ёсны үүднээс үзвэл 1960-аад оноос Монголын төрийн байгууламжийн суурь болсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарилалт, улмаар түүний нэгжийн удирдлагын тогтолцоонд ноцтой гажуудал гарсан юм. Ялангуяа баг, сум, хот, хороо зэрэг нэгжүүдийг нутаг дэвсгэрийн зарчмаар биш, харин нийгэмчилсэн аж ахуйн нэгж, шинээр үүссэн хот, тосгоныг баримтлан тогтоож удирдлагыг нь хөдөө аж ахуйн нэгдэл (ХААН), сангийн аж ахуй(САА) буюу уул уурхайн үйлдвэр зэрэг тухайн үеийн аль нэгэн аж ахуйн нэгжийн даргад хавсарган дайх болжээ. Тэгснээр “иргэний захиргаа” гэх түүхэн уламжлал тасарч, төрт ёс алдагдаж бүдгэрсэн байна.

Ийм үед иргэн – төрийн удирдлага, нэгжийн удирдлага – иргэний гэхээсээ “сум – сангийн аж ахуй”, “сум – нэгдэл”, “уурхай – хороо захиргаа” болж, засаг захиргаа нь хүн амтайгаа улсын иргэний хувьд биш “нэгдлийн гишүүн”,

<sup>15</sup> Цэдэнбал.Ю Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг II боть УБ., 1967. т. 124

<sup>16</sup> Мөн тэнд т. 124

<sup>17</sup> БНМАУ-ын түүх УБ., т. 197

“сангийн аж ахуйн ажилчин” гэх маягаар зөвхөн аж ахуйн нэгжийн ажилтны статусаар нь харилцах болсон байна.

Сумыг хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн тоолонгоор байгуулж удирдагчаар нь аж ахуйн удирдагчдыг хавсаргасан явдлыг өнгөн талаас нь харвал баг, сумын захиргааны даргын цалин, албан байр, унааны зардлыг хэмнэж байгаа хэрэг юм. Сумдыг нутаг дэвсгэрийн зарчмаар бус аж ахуйн нэгжийн тоогоор байгуулж удирдлагыг нэгжийн эрх баригчдад хавсаргаснаар сум нь засаг захиргаа, аж ахуйн нэгж болжээ.

Иргэдэд их төлөв нэгдлийн гишүүдийн өрх, ам бүлд иргэний хувьд засаг төрөөс санхүүжилтээр үзүүлбэл зохих ерөнхий боловсрол, эрүүл мэнд, халамжийн зэрэг үйлчилгээний материаллаг бааз, хөрөнгийн эх үүсвэрийг хөдөө аж ахуйн нэгдэлд даалган үүрүүлсэн байна. Энэ нь үзэгдэх талаасаа нам төрийн халамж мэт боловч угтаа нэгдэлчдийн нийгэмчилсэн өмч, хөдөлмөрийн үр дүнд бий болсон тэдний өөрсдийн хөрөнгөөр ихэвчлэн хийгддэг байв.

**Abstract:** This article tells about collectivization in agriculture, changes the organization in soum and changes the Mongolian administrative. Also I tried to put toward proposal in this archive and academic paper.

#### Эшлэл, зүүлт

1. БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1965 он №6
2. БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1966 он №1
3. Цэдэнбал.Ю Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг II боть УБ., 1967 он
4. Болдбаатар.Ж Лүндээжанцан.Д Монгол улсын төр эрхзүйн түүхэн уламжлал УБ., 1997 он
5. БНМАУ-ын түүх. УБ., 1969 он
6. Дамдиндорж.Г Хөдөө аж ахуйн нэгдэл ба түүний удирдлагын эрх үүрэг УБ., 1965 он
7. Монгол улсын түүх. УБ., 2003 он
8. Сономдавга.Ц БНМАУ-ын орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд (1921-1965) УБ., 1967 он
9. Сүхбаатар.Д, Хасбаатар.Т Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалтын түүхэн уламжлал УБ., 2011 он
10. Чимид. Б Багийн өнгөрсөн одоо ирээдүй УБ., 2002 он
11. Чимид. Б Үндсэн хуулийн үзэл баримтлал: нутгийн удирдлага гуравдугаар дэвтэр УБ., 2004 он